

ХАГАС ЗУУН ЖИЛ ХӨДӨЛМӨРЛӨЖ ЯВАА НЭГЭН БУУРЛЫН ТУХАЙ

С. Энхцэцэг *

Хүний амьдрал гэдэг богино юм шиг атлаа урт юм. Хүний хорвоод тавин жилийг насална гэдэг амаргүй атал улс орныхоо төлөө тасралтгүй 50 жил хөдөлмөрлөж зүтгэнэ гэдэг ховорхон тохиох хувь заяа гэлтэй. Дөрвөн жилд нэг удаа тохиодог 2 дугаар сарын 29-ний билэгт сайн өдөр (2008 онд) Монгол улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, ахмад дипломатч, МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийн багш, шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Ц.Гүрбадам улсдаа 50 жил зүтгэсний хөдөлмөрийн алдрыг нь манай сургуулийн хамт олон, хамтран зүтгэж байсан найз нөхөд, намын нөхөд, эрдэмтэн багш, шавь нар болон оюутан сурагчид нь ёслол төгөлдөр тэмдэглэж өнгөрүүлэв.



Ёслолын арга хэмжээг нээж ОУХС-ийн ОУЭЗХ-ны тэнхмийн эрхлэгч доктор, профессор Б.Хулдорж уг хэлж байгаа нь

Энэхүү төлөв даруухан атлаа хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж олныг бодуулсан үйл явдал нь ирээдүй хойч үе болсон оюутан, залуучууддаа нэр төртэй амьдрах, улс орон, ард түмэндээ хүндлэгдсэн иргэн байхын утга учрыг

* МУИС, ОУХС-ийн багш, докторант

таниулахын зэрэгцээ “ах нь сургаж дүү нь сонсдог”, ахмадаа хүндэтгэдэг монгол ухаанаа дээдлэсэн томоохон арга хэмжээ болсон юм.

Уг арга хэмжээнд хүрэлцэн ирсэн хүндэт зочдын дунд Монголын төр, нийгмийн төлөө зүтгэж байсан ахмадууд, дунд насныхан, аж үйлдвэрийн салбарын гавъяатнууд, төр, засгийн газар, төрсөн аймаг, сумын нь төлөөлөгчид хүндэтгэл үзүүлэхээр ирсэн нь түүний улс төр, эдийн засаг, дипломат, шинжлэх ухаан, боловсрол зэрэг олон салбарт ажиллаж байсан чадварлаг боловсон хүчин байсны нэг тод илрэл юм. Хүндэт зочдын дунд Сайд нарын зөвлөлийн орлогч дарга асан аж үйлдвэрийн гавъяат ажилтан, доктор М.Пэлжээ, аж үйлдвэрийн яамны сайдын алба хашиж байсан эдүгээ шинжлэх ухааны доктор (Sc.D) Д.Батхуяг, Дамдинсүрэн, дипломатч Дулмаа, МУИС-ийн магистр, докторын сургалтын албаны дарга, шинжлэх ухааны доктор (Sc.D), гавъяат багш, академич А.Мекей, олон жил хамтран зүтгэсэн Дагвадорж, Хажидсүрэн, Мужаан, Цэвээн, Жамц, хөдөлмөрийн баатар Чимиддорж, аж үйлдвэрийн ахмад зүтгэлтэн Хандмаа, Цэмбэлдорж зэрэг улс даяар нэр алдраа цуурайтуулсан олон хүн ирсэн нь сонирхолтой байв.

Ц.Гүрбадам багшийн хөдөлмөрийн алдрыг тэмдэглэх ёслолын ажиллагааг ОУХС-ийн захирал, доктор, профессор Н.Алтанцэцэг нээж үг хэлэхдээ: “Манай сургуулийн хамт олон сургуулийнхаа хамгийн ахмад багш, бид бүхний хайрлаж хүндэтгэж явдаг Ц.Гүрбадам багшийнхаа төр, улсдаа хөдөлмөрлөсний 50 жилийн ойг тэмдэглэж байгаа нь зөвхөн түүний улс орондоо хөдөлмөрлөсөн 50 жил гэсэн тоондоо байгаа юм бишээ. Гүрбадам багш маань Монгол улсын хөгжлийн төлөө ажиллаж байсан аль ч салбартаа хөдөлмөр, мэдлэг, мэргэжлийн ур чадвар, дадлага туршлага, ясны ажилч зарчимч чанар, ёс суртахуун болон харилцааны өндөр соёл, ажил зохион байгуулах чадвар зэргээрээ тэргүүлж явсан манай улсын тэргүүний сэхээтнүүдийн нэг юм. Одоо ч боловсролын салбарт мэдлэг чадвар, ажлын арвин их туршлагаа хойч үедээ өвлүүлэн сургахад хичээл зүтгэл гаргаж байгаа багш юм. Энэхүү зохион байгуулж байгаа хөдөлмөрийн алдрыг тэмдэглэх ёслолын ажиллагаа нь Ц.Гүрбадам багшийн туулж ирсэн түүхэн хагас зуун жилийн хөдөлмөрийг тэмдэглэхийн зэрэгцээ иргэн бүр ялангуяа манай залуучууд багш шиг маань улс орныхоо төлөө хичээл зүтгэл гаргаж хөдөлмөрлөж байхыг захисан нэгэн ёсны сургамж хичээл болж байгаа юм. Бид хүний боловсрол, хүний хөгжлийн талаар их ярьж бичиж байгаа. Гэвч харамсалтай нь яриа, илтгэл газар дээрээ хэрэгжиж биеллээ олохоос илүү цаас болон замхрах нь элбэг болжээ. Хүнийг хөгжүүлэх, хүмүүжүүлэх ажлын хамгийн хүртээмжтэй, ойлгомжтой арга замын нэг нь яах аргагүй ахмадуудаасаа сурах явдал гэж би боддог. Манай сургуулийн хамт олон, багш нар, оюутан залуучууд маань ийм сайхан хүнтэй хамт ажиллаж, хичээл заалгаж, үгийг нь сонсож тавьсан шаардлагыг нь биелүүлж байгаадаа баяртай байдаг. Манай хамт олны өмөг түшиг болж эцгийн хайраар биднийг хайрлаж, эрдмийн ухаанаар мэдлэгжүүлж, амьдралын ухаанаар сургаж байдаг багшдаа талархаж байдгаа илэрхийлье” гэж онцлон тэмдэглэв.

Дараа нь тус сургуулийн Олон улсын эдийн засгийн харилцааны тэнхмийн эрхлэгч, доктор, профессор Б.Хулдорж “Ц.Гүрбадам бол Монгол улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, ахмад дипломатч, билгүүн эрдэмтэн багш мөн” гэсэн сэдвээр илтгэл тавив. Илтгэл нь дараах чиглэлтэй байсныг хураангуйлан толилуулъя. Үүнд:

Нэг. Бага, өсвөр нас буюу мэдлэгийн төлөө зүтгэсэн нь

Тэртээ усан тахиа жилийн өвлийн адаг сарын хоринд, аргын тооллын 1934 оны 2 дугаар сарын 12-нд хүмүүс цагаан сардаа бэлтгэж байсан ид үед малчин ард Цэрэнгийн нэгэн хүү мэндэлж хотол олноо баясгасан нь өнөөдөр хөдөлмөрийн алдраа тэмдэглэж байгаа Монгол улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, ахмад дипломатч, билгүүн эрдэмтэн Гүрбадам багш маань байжээ. Шинээр мэндэлсэн хүүгийн тухай дэлгэрэнгүй мэдээ, мэдээлэл өнөө бидэнд хараахан байхгүй байгаа ч гэсэн төрсөн даруйдаа цовоо сэргэлэн дуутай, өсөлт бойжилт сайтай, овсгоотой нэгэн байсан гэдгийг 75 насны өнөөдрийн өндөрлөгөөс нь харахад тааж цөхөх юмгүй мэт бодогдоно.

Ц. Гүрбадам багшийн уугуул нутаг нь Сэцэн хан аймгийн Хөвчийн Жонон вангийн хушуу, одоогоор Хэнтий аймгийн Биндэр сум. Гүрбадам хүүгийн балчир нас нь малын захад хурга, тугалын бэлчээрт жирийн малчин хүүгийн нэгэн адил өнгөрчээ. Харин найман настайдаа Биндэр сумын дунд сургуульд ороод 1949 онд төгсч, улмаар 1952 онд Улаанбаатар хотын 1 дүгээр дунд сургуулийг, 1957 онд Москва хотын Хөнгөн үйлдвэрийн технологийн дээд сургуулийг дүүргэсэн манай анхны инженерүүдийн нэг юм.

Балчир насанд нь буюу 1938 онд эцэг Цэрэнг нь улс төрийн хилс хэргээр цаазалсан хэдий ч “би эрдэм сурч юмны учир олох ёстой” гэсэн зорилго өмнөө тавьсан Гүрбадам хүү ийнхүү Монголын аж үйлдвэрийн салбарыг шинэ хүчээр сэлбэв. Дээд боловсрол эзэмшиж байх тэр үед нь ЗХУ-ын өмнөх удирдлагын үйл ажиллагаанд бодит үнэлгээ өгөх, ололт амжилтаа өөр өнцгөөс харах анхны оролдлого хийгдэж, хаагдмал байсан нууцлаг үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийх болсон зэрэг нь залуу Гүрбадамд нилээдийг бодогдуулсан нь тодорхой. Аливаа асуудалд нухацтай хандах, улыг нь олохын төлөө эрэлхийлэх чадварыг энэ л үед эзэмшсэн болов уу.

Хоёр. Мэддэгээ мэдсэн нь буюу Төрийн зүтгэлтэн болсон нь

Сургуулиа төгссөн залуухан инженер тэр үеийн Аж үйлдвэрийн яаманд 1957 онд инженерээр хөдөлмөрийн гараагаа эхэлж боловсон хүчин сонгодог тэр үеийн хатуу шалгуурыг амжилттай даван туулж, нам, төрийн ирээдүйтэй албан хаагч болохоо харуулж чадсан учир АУЯ-ны Үйлдвэр техникийн хэлтсийн дарга, улмаар 1960 онд МАХН-д элсээгүй байхдаа орлогч сайд болон дэвшжээ. Ийнхүү төрийн зүтгэлтэн болох итгэл найдварыг Аж үйлдвэрийн яаманд ажилласан 10 орчим жилд төрүүлж чадсан нь өнөөгийн төрийн түшээдэд нэн сургамжтай санагдана.

Гүрбадам багш Аж үйлдвэрийн яаманд байхдаа ажил төрөлдөө хичээл зүтгэлтэй нэгэн гэдгээ харуулаад зогсоогүй ирээдүйн амьдралынхаа хань Батын Нямцоо гуайтай учирч өрх гэрийнхээ ханыг тэрэлж үр хүүхэдтэй болсон хугацааг нь харвал энэ жил мөн л хагас зуун жилийн ойтойгоо золгож байна. Өөрийгөө засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас хэмээх мэргэн ардынхаа сургаалийг ийнхүү дагаж биелүүлжээ.

Ирээдүйтэй боловсон хүчинээр төрийн эрх баригч нам хүчээ сэлбэдэг тэр л жаягаар Ц. Гүрбадамыг МАХН 1966 онд төв аппаратгаа татаж Аж үйлдвэр, эдийн засгийн байгууллагуудын хэлтсийн эрхлэгчээр томилжээ. Энэхүү өндөр нэр хүндтэй албыг өнөөдөр та бидний дунд сууж байгаа Мятавын Пэлжээ

гуайгаас хүлээн авч байсан байна. Пэлжээ даргадаа энэ ялдамд аз жаргал, урт удаан наслахын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье. МАХН-ын Төв Хорооны хэлтсийн эрхлэгчийн өндөр албыг 15 жил тасралтгүй хашсан хүн олонгүй гэдэгт миний бие эргэлзэхгүй байна.

Энэ хугацаанд Ц. Гүрбадам АИХ-ын депутатаар 4 удаа сонгогдож 16 жил төр түшилцсэний дээр АИХ-ын Төлөвлөгөө-төсвийн байнгын комиссын даргаар 3 удаа сонгогдон 13 жил ажилласан нь түүний төрийн зүтгэлтэн байсан цар хүрээг нь харуулна. Өөрөөр хэлбэл Монгол улсын хамгийн эрчимтэй хөгжлийн үе болох 1971–1984 оны төлөвлөгөө, төсөв энэ хүний гараар орж батлагдаж байжээ.

Ц.Гүрбадам багш төрийн албыг ширээний араас хашиж, байшин дотроос залгуулж байгаагүйг түүний хөдөлмөрийн талбарт бүтээсэн суврагаас нь харж болно. Инженерийн хувьд нийгмийн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, хөдөлмөрчдийн идэвх, санаачлагыг өрнүүлэх үүднээс 1960-аад оноос аж үйлдвэрийн салбарт төлөвлөлт урамшууллын шинэ систем, 1970-аад оноос макро-микро эдийн засгийн өөрчлөлтүүдийг санаачлагч, хэрэгжүүлэгчдийн нэг байсан. Энэ чиглэлээр Улаанбаатар хотын Талхны үйлдвэр, Чихэр боовны үйлдвэрт гадаад дотоодын тэргүүн туршлагыг нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанар шалгагч Доржсорогийн санаачилга, алдарт оёдолчин Ц. Амгалан, нэхмэлчин Б. Гүнжлхам, нэгдсэн бригад зохион байгуулсан уурхайчин А. Орногвайн санаачлагыг дэмжиж нийтийн хүртээл болгож байсныг бидний үе гэрчилнэ.

Аж үйлдвэрийн салбарын инженер техникийн ажилтан, удирдах боловсон хүчин бэлтгэх зорилгоор 1969 онд Политехникийн дээд сургууль, Удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх институт байгуулах асуудлыг санаачлан холбогдох шийдвэр гаргуулж байснаас нь төрийн түшээ Ц. Гүрбадамын сэтгэлгээ, үйл ажиллагааны цар хүрээг харж болно.

Төрийн нүсэр албыг хашихын зэрэгцээ 1957 оноос Үйлдвэрийн теникумд багшилж, Удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх институтэд тэнхмийн эрхлэгчээр хавсран ажиллаж байлаа. Түүний тэр үеийн гарын шавь нарын дундаас төрсөн хөдөлмөрийн баатар Чимиддорж гуай өнөөдөр та бидний дунд сууж байна.

Ц. Гүрбадам багш ирээдүйтэй боловсон хүчнийг таньж, зохих албан тушаалд нь зоригтой дэвшүүлдэг байсны ачаар олон арван төрийн түшээдийг төрүүлжээ. Тэдгээрээс өнөөдрийн энэ арга хэмжээнд Батхуяг, Дагвадорж, Дамдинсүрэн, Дулмаа зэрэг сайдууд, Хажидсүрэн, Мужаан, Цэвээн, Жамц зэрэг төрийн түшээд хүрэлцэн ирсэн байна. Төр, засгийн ахмад зүтгэлтэн та бүхэнд ОУХС, ОУЭЗХ-ны тэнхмийн хамт олны өмнөөс гүн талархлаа илэрхийлж, эрүүл энх сайн сайхныг хүсэн ерөөе.

Гурав. Монгол улсын гадаад харилцаанд Ц. Гүрбадамын оруулсан хувь нэмэр

Монгол улсын төр засаг шилдгийн шилдэг сэхээтнээ ЗХУ-д Элчин сайдаар томилдог заншлаараа улс орны нийгэм, эдийн засагт онцгой эргэлтийн эхлэл тавигдсан 1984 онд “Энх тайван, социализмын асуудал” сэтгүүлд эрх баригч намаа төлөөлөн сууж байсан Ц. Гүрбадамаа ЗХУ-д суух Онц бөгөөд бүрэн эрхэт Элчин сайдаар томилсон. Энэ бол Монгол улсад төр засгийн удирдлага солигдож байсан, зах зээлийн шинэ механизм, сэтгэлгээг бий болгох өөрчлөлт эхэлж улмаар социализмыг аврах оролдлогыг улс орны дотоодод

болон тэр үеийн ЭЗХТЗ – ийн хүрээнд хийж байсан онцгой үе билээ. Монгол улс гадаад гол тулгуур улсдаа шалгарсан улс төрчөө явуулахаас өөр сонголт байгаагүй нь ч ойлгомжтой. Улс орныхоо итгэл найдварыг ч тэр ороо бусгаа цаг үед Элчин сайд Ц. Гүрбадам алдаагүй.

Манай төр, засгийн нэрт зүтгэлтэн, Монголын ард түмний шалгарсан удирдагчдын нэг Ю. Цэдэнбал агсны амьдралын хамгийн эмгэнэлтэй, эх оронч хэн бүхний сэтгэл өвдөм үе Ц.Гүрбадамыг Элчин сайдаар томилсонтой давхцсаныг тохиолдлын гэж үзэх үндэсгүй билээ.

Дипломат харилцааг эдийн засагжуулах талаар санаачилгатай, үр бүтээлтэй ажиллаж байсныг тэр үед хэрэгжүүлж байсан зарим төсөл харуулна. Тухайлбал, Финлянд улсаас 4 сая орчим швейцари франкийн хүүгүй зээл авч Багахангайд мах комбинат барих болон Улаанбаатарт сүү савлах “Элекстер” төхөөрөмж хэрэглэх, баглаа боодол үйлдвэрлэх асуудлыг шийдвэрлэж байжээ.

Дөрөв. Мэдсэнээ бусадтай хуваалцаж залгамж үеэ бэлтгэж буй нь

Ц.Гүрбадам багш зөвхөн төрийн албанд бусдад үлгэр жишээ болсон төдийгүй, нэрт эрдэмтэн сурган хүмүүжүүлэгч гэдгийг бид илүү мэднэ. Өөрийн эрхэлж буй ажлаа шинжлэх ухааны үндсэн дээр хөгжүүлэх үүднээс төр, нийгмийн зав зай багатай алба хашиж байх үедээ “БНМАУ–ын шинжлэх ухаан–техникийн удирдлагыг болосронгүй болгох асуудалд” сэдвээр боловсролын докторын зэргийг 1974 онд, “БНМАУ–д шинжлэх ухаан–техникийн дэвшлийг түргэтгэх нийгэм–эдийн засгийн хүчин зүйл, механизм” сэдвээр шинжлэх ухааны докторын зэргийг 1986 онд Москва хотод тус тус хамгаалжээ. Үүний зэрэгцээ олон тооны эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, үзэл баримтлал, ном өгүүлэл бичиж хэвлэн нийтлүүлснээс орос, англи, франц, герман, польш, чех, унгар, араб, япон хэл дээр нийтлэгдсэнийг дурдсу. Мэддэг эрдэмтнийг эрдэмтэй хүн, бичиж бүтээдэг хүнийг эрдэмтэн хүн гэдэг билээ. Ц. Гүрбадам багш нийт 300 гаруй хэвлэлийн хуудас бүтээл туурвиж нийтийн хүртээл болгосон байна.

Эрдэмтэн Ц. Гүрбадам дипломат албаа дуусгаад Засгийн газрын төрийн бодлого судлах төв, Техникийн их сургуулийн харьяа Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, секторын эрхлэгчийн ажил хийж байлаа. Ц.Гүрбадам багш бол эрдэмтэй, төрийн зүтгэлтэн бөгөөд 2001 оноос манай хамт олонтой ажиллаж байгаа хайртай өмөг түшиг, билгүүн эрдэмтэн хүн юм. Сэтгэлгээ хэр залуу байна, мэдлэгээ хойч үедээ өвлөн үлдээх чадамж нь аль хэр өндөр байна гэдгийг Гүрбадам багшийн сурган хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмэр тодоор харуулж байна.

Тав. Төгсгөл буюу дүгнэлт

Ийнхүү Монголын улс төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, ахмад дипломатч, билгүүн эрдэмтэн багшийнхаа талаар та бүхэнд хүргэх гэсэн миний илтгэл өндөрлөж байна. Би энд Ц. Гүрбадам багшийнхаа хийсэн ажил бүрийг тоочих гэж оролдсонгүй. Багшаасаа эмээхийн хирээр түүнийг бас магтаж чадсангүй. Энэ нь хөдөлмөрийн алдрыг нь тэмдэглэж байгаа багшийнхаа сэтгэлд нь нийцүүлэхийн тулд магтаалд дургүй багшийнхаа аяыг нь дагаж буй миний сонгосон зам болохоос түүний хийсэн, бүтээсэн нь хомсынх биш юм шүү

гэдгийг тэмдэглэхийг хүсч байна. Бүтээсэн хүний хөдөлмөрийг үнэлдэг үед Ц. Гүрбадам багшийг Сүхбаатарын одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Алтан гадас одон, ойн медалиудаар ОХУ-ын “Улс түмнүүдийн найрамдал одон”-гоор шагнаснаас гадна Эрчим хүч, уул уурхай, хөнгөн үйлдвэр, шинжлэх ухаан, боловсрол, үйлдвэр, худалдааны зэрэг нийт 7 салбарын тэргүүний ажилтан цол тэмдэг хүртсэнийг хэлэхэд л ямар магтаалын эзэн байж болох нь тодорхой байгаа буйзаа.

Төр нийгэмдээ хагас зуун жил зүтгэж энэ шороон хулгана жил 75 насны сүүдэр зооглож буй буурал багшийнхаа хөдөлмөрийн алдрыг тэмдэглэх манай тэнхмийн санаачлагыг тал бүрээр дэмжсэн Олон улсын харилцааны сургуулийн захиргаа, захирал доктор профессор Н. Алтанцэцэг танд хамт олныхоо өмнөөс гүн талархлаа илэрхийлье. Мөн бидний баярыг хуваалцан төлөөлөгчөө ирүүлсэн МАХН-ын, нарийн бичгийн дарга С.Барсболд, Гадаад хэргийн яамны дэд сайд Н.Энхмандах, ОХУ-аас тус улсад суугаа Элчин сайдын яам, Элчин зөвлөх Мостыка Иван Сергеевич, Нэгдүгээр нарийн бичгийн дарга Ганжуров Владимир Цеденович, Хэнтий аймаг, Биндэр сумын удирдлага, МУИС-ийн магистр, докторын албаны дарга, академич Мекей, МУ-ын ШУТИС-ийн багш, академич Батмөнх нарт талархлаа илэрхийлье.

Энэ ялдамд Ц. Гүрбадам багштай үе үед хамтран ажиллаж төр, нийгмийнхээ төлөө чөмгөө дундлан зүтгэсэн төрийн нэрт зүтгэлтэн, Сайд нарын зөвлөлийн орлогч дарга асан М.Пэлжээ, төрийн сайд асан Батхуяг, Дулмаа, Дамдинсүрэн, Дагвадорж, төрийн зүтгэлтэн Хажидсүрэн, Мужаан, Цэвээн, хөдөлмөрийн алдартан Чимиддорж, Махвал, Хандмаа гуай нарт энэ өдрийн баярыг бидэнтэй хуваалцахаар ирсэнд нь нийт багш, оюутан, хамт олныхоо өмнөөс гүн талархлаа илэрхийлж, эрүүл энх, урт удаан наслахын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье” гэв.

ОУХС-ийн тэнхмийн эрхлэгч, доктор, профессор Б.Хулдоржийн илтгэлийн дараа зочид, төлөөлөгчид баяр хүргэж үг хэлсэн бөгөөд Ц.Гүрбадамыг “Хүндэт дипломатч”, “Төрийн албаны хүндэт ажилтан” цол тэмдгээр шагнасан нь хүмүүсийн анхаарлыг татаж байв.

Гадаад Хэргийн дэд сайд Н.Энхмандах “Гүрбадам гуай бол маш олон талын авъяастай, чадалтай боловсон хүчин мөн. Мэргэжил нь гэвэл гутлын инженер. “Сапожник хүн ямар дипломатч байдаг юм” гэж ярьдаг хэмээн би сонссон. Үнэн хэрэг дээрээ дипломатч гэдэг хүн улс орныхоо сапожник юм л даа. Үнэн хэрэг дээрээ хүний нүүр, царайг гутал нь харуулдаг шигээ дипломатч хүн улс орныхоо нүүр царайг харуулдаг. Өөрөөр хэлбэл гутал нь хэр өнгөтэй байвал хүн өнгөтэй харагддаг, дипломат алба нь хүчтэй байвал улс орон нь тэр хэмжээгээр хүчтэй байдаг гэх мэтээр наргиантай дүгнэлт хийн алга ташуулж байв. Ц.Гүрбадам гуай бол тэр социализмын үе, 1980-аад онд гадаад харилцааг эдийн засагжуулах талаар ихээхэн хөөцөлдөж байсан юм гэж онцлон тэмдэглэв.

МУИС-ийн МДСА-ны дарга А.Мекей хэлэхдээ: “Ц.Гүрбадам багш Монгол улсыг үйлдвэржүүлэхэд гавъяа байгуулсан, түүхийн өмнө гавъяатай хүн шүү” гэдгийг онцлон тэмдэглэсэн бол ХХҮЯ-ны сайд асан Ж.Дулмаа “Ц.Гүрбадам 1966 оноос НТХ-д 15 жил аж үйлдвэр хариуцсан хэлтсийн эрхлэгчээр ажиллах хугацаандаа Монголын нийт аж үйлдвэрийг хөгжүүлэхэд ихээхэн зүтгэж гавъяа байгуулсан бөгөөд тэр үеийн МАХН-ын их хурал, бүгд хурлуудад аж үйлдвэрийн талаар дэвшүүлдэг шинэ чиглэл, зорилтууд, тогтоол, шийдвэр, хэлэх үгүүд түүний гараар орж, гардаг байсныг би сайн мэднэ” гэлээ.

МАХН-ын нарийн бичгийн дарга С.Барсболд хэлэхдээ: “Би 1982-1986 онуудад Москвад оюутан байхдаа Гүрбадам гуайн бичсэн аж ахуйн механизмыг төгөлдөржүүлэх тухай өгүүллэгүүдийг уншиж ихэд гайхаж манай улс чинь энэ социализмд шинэ элементүүд оруулж байгаа юм байна хэмээн бид гайхаж хоорондоо маргалддаг байсныг сайн санаж байна” гэв.

Оросын Холбооны Улсын ЭСЯ-аас ирүүлсэн баярын бичгийг тус яамны нэгдүгээр нарийн бичгийн дарга В.Ц.Ганжуров уншиж гардуулаад: “Уважаемый господин Ц.Гурбадам ваш личный вклад в развитие двусторонних отношений, дружбы наших народов по достоинству оценено Правительством СССР. Ваши научные труды широко известны в России” гэж цохон тэмдэглэв.

Ёслолын арга хэмжээний төгсгөлд Ц.Гүрбадам багш бүх хүмүүст хандан талархал илэрхийлж үг хэлэхдээ “Та нарынхаа их итгэл найдвар, хүндэтгэл, сайн сайхны ерөөлийн хариуд би үзгээ барьж чадах бүх хугацаандаа судалгааныхаа ажлыг үргэлжлүүлэн шинэ бүтээл туурвиж өргөн барих болно” гэж амлав.



Ёслолын арга хэмжээнд хүрэлцэн ирсэн зочид

Ёслолын арга хэмжээнд оролцсон маш олон хүн баяр хүргэж үг хэлсэн боловч сэтгүүлийн нийтлэлийн хэмжээ бага учир бүгдийг нь багтааж чадаагүйдээ хүлцэл өчье.